



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/28

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн авто машин шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ш.Нохойжав -Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Б.Батнасан -Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Нямжаргал -Төрийн бус байгууллагын төлөөлөл

Д.Батсайхан - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Г.Нэмэхбаяр - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Ш.Нохойжав /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Г.Нэмэхбаяр /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД